


# ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/01/02-2023/01/06

## ТОП 20 индекс



МХБ-ын Топ 20 индекс өнгөрсөн долоон хоногт 37,021 нэгжид хүрч өнгөрсөн 7 хоногоос 1.45%-иар буураад байна. Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 6.78 их наяд ₮ хүрээд байна.

Энэ оны эхний 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 74 компанийн 2.1 тэрбум ₮-ийн 3.1 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан ба арилжааны дүн 74%-иар буурсан байна.

Үүнээс 334.9 сая ₮-ийн ХБҮЦ, 84 сая ₮-ийн компанийн бонд, 67 сая ₮-ийн хамтын хөрөнгө оруулалтын сан, 1.65 тэрбум ₮-ийн хувьцааны арилжаа хийгдсэн байна.

## ХАМГИЙН ИХ ДҮНГЭЭР АРИЛЖИГДСАН

Богд Банк	613,705,655
Голомт Банк	204,012,736
АПУ	199,527,793
Ард санхүүгийн нэгдэл	148,688,586
Алтайн зам	85,500,000

## ХАМГИЙН ИХ ӨСӨЛТТЭЙ

	Үнийн дүн	Өсөлт
УБ-БҮК	167,611	28.65%
Хөх Ган	177,423	28.26%
Жуулчин дюти фрий	1,475,500	16.82%
Могойн гол	21,160	15.00%
Монгол дизель	3,832	14.97%

## ХАМГИЙН ИХ БУУРАЛТТАЙ

	Үнийн дүн	Бууралт
Тэнгэрлэг медиа групп	2,452,830	-28.40%
Стандарт ноос	18,225	-12.72%
Ард кредит ББСБ	11,811,827	-12.49%
Ард даатгал	22,692,467	-12.19%
Материал импекс	24,000	-11.11%

Хамгийн их дүнгээр арилжаалагдсан эдгээр хувьцаанууд нь өнгөрсөн 7 хоногийн нийт хоёрдогч зах зээлийн хувьцааны арилжааны 75.7%-ийг эзэлж байна. Богд Банк өнгөрсөн 7 хоногт хамгийн өндөр дүнгээр арилжаалагдсан бол Голомт банк, АПУ ХК нь түүний өмнөх долоон хоногт ч бас арилжааны дүнгээр тэргүүлсэн компаниуд болсон байна.

Өнгөрсөн долоон хоногт УБ-БҮК 28.65%-ийн өсөлт үзүүлсэн боловч арилжааны дүн харьцангуй бага хийгдсэн байна. Хамгийн их өсөлт үзүүлсэн ангиллын компаниудын арилжаа нийтдээ 1.8 сая ₮-өөр хийгдсэн бол түүний өмнөх долоон хоногт 1.18 тэрбум ₮-т хүрч байв.

2022 оны сүүлчийн 7 хоногт ханшийн өсөлтөөр тэргүүлж байсан Тэнгэрлэг медиа групп өнгөрсөн 7 хоногт ханшийн уналтаар тэргүүлсэн байна. Мөн ард даатгал ХК-ийн хувьцааны ханш хамгийн өндөр буюу 22.7 сая ₮-ийн арилжаа хийгдэж 12.19%-ийн уналт үзүүлсэн байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

# ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/01/02-2023/01/06

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- **Жуулчин Дюти Фрий ХК хувьцаа худалдан авах тендер зарлалаа**- "Таван Богд Трейд" ХХК нь бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй энгийн хувьцааг сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргасан байна.  
Санал болгож буй үнэ: **69,700₮**  
Худалдан авах тоо ширхэг: **19,007 ширхэг**  
Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: **2022/12/23**  
Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: **2023/01/24**



- **“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хоёрдогч зах зээлийн арилжаа 2023/01/09-ний өдөр эхлэнэ**



МХБ ХК-ийн IPO-д оролцсон нийт хөрөнгө оруулагчдын 50 мянган төгрөг хүртэлх хувьцааны захиалгыг 100% биелүүлж, 50 мянган төгрөгөөс дээш үнийн дүнтэй захиалгыг 11.4%-иар хувь тэнцүүлэн биелүүлсэн байна. 2023/01/09-ний өдрөөс тус компанийн үнэт цаасыг хоёрдогч зах зээлийн арилжааг “MSE” үсгэн кодтойгоор эхлүүлэхээр болсон байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

